



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/381

Есөнбулаг сум

Тусгай зөвшөөрөл шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2.1 дэх заалт, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.9 дэх хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангаж, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл авахаар материалаа ирүүлсэн аж ахуйн нэгжүүдэд худалдах тусгай зөвшөөрлийг хавсралтаар шинээр олгосугай.

2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомж, шаардлага журмыг зөрчсөн тохиолдолд зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газар (Н.Мэндбаяр), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 27-ны өдрийн 1/381 дугаар
захирамжийн хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОСОН АЖ АХУЙН НЭГЖҮҮД

Д/д	Сумын харьяалал	Аж ахуйн нэгжийн нэр	Дэлгүүрийн нэр	Байрлал	Худалдаа үйлчилгээний хэлбэр
1	Алтай сум	Аж алтан нутгийн үндэс ХХК	Family market хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
2	Дарив сум	Хотойн Хандмал ХХК	Хүрэн хайрхан хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
3	Есөнбулаг сум	Буянт шар далангийн нуруу ХХК	Буянт хүнсний дэлгүүр	Оргил баг	Худалдах
4	Есөнбулаг сум	Номгур ХХК	Түмэн мини маркет	Индэрт баг	Худалдах
5	Есөнбулаг сум	Мөнх түмэн Алтай ХХК	Их тунамал хүнсний дэлгүүр	Баянхайрхан баг	Худалдах
6	Жаргалан сум	Согоот нуруу ХХК	Бүрэн буудай хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах
7	Эрдэнэ сум	Хараат өгөөмөр ХХК	Өгөөмөр хүнсний дэлгүүр	Сумын төв	Худалдах

